



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/492

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн бага боловсролын Бэлтгэл хөтөлбөрийг нэгдүгээр, Монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хоёрдугаар, Математикийн сургалтын хөтөлбөрийг гуравдугаар, Яриа бичгийн сургалтын хөтөлбөрийг дөрөвдүгээр, Биет зүйлийн сургалтын хөтөлбөрийг тавдугаар, Айзамт хөдөлгөөнт дасгалын сургалтын хөтөлбөрийг зургаадугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Бэлтгэл, Монгол хэл, Математик, Яриа бичиг, Биет зүйл, Айзамт хөдөлгөөнт дасгал сургалтын хөтөлбөрийг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн сургуулийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллахыг сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн захирал /Б.Батсайхан/-д даалгасугай.

3. Сонсголын бэрхшээлтэй 29 дүгээр тусгай сургуулийн Бэлтгэл, Монгол хэл, Математик, Яриа бичиг, Биет зүйл, Айзамт хөдөлгөөнт дасгалын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга /Т.Ням-Очир/, Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД



ЦОГЗОЛМАА

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2018.08.08.саян.08 өдрийн А/492
тоот тушаалын захирамж

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН 29
ТУСГАЙ СУРГУУЛИЙН БАГА БОЛОВСРОЛ
“МАТЕМАТИК” ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургууль байгуулагдсан цагаасаа эхлэн 1990-ээд оныг хүртэл тухайн үеийн ЗХУ-ын сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын хөтөлбөрийг орчуулан сургалтад хэрэгжүүлж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Одоо мөрдөж байгаа ЕБС-ийн математикийн сургалтын цөм хөтөлбөр нь олон улсын чиг хандлагад баримжаалсан, сурагчдын өдөр тутам, ахуй амьдралд зайлшгүй хэрэгцээт мэдлэг, чадварыг олгоход чиглэгдэж байгаа боловч зарим агуулга нь сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд хэрэгжүүлэхэд хүндэвтэр, ангийн түвшинг бууруулж заах шаардлага үүсдэг. Сурагчид бага боловсролын түвшинд математикийн анхан шатны мэдлэг, чадвар эзэмшихийн зэрэгцээ түүнийгээ ахуй амьдралдаа хэрэглэх, бие даан болон хамтарч ажиллах, өөрийгөө хянан зохицуулах чадвар, сурах арга барил эзэмших нь нийгмийн болон хувь хүний хөгжлийн хэрэгцээ болж байна.

Иймд сонсголын бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн болон сурах арга барилын онцлогийг дэмжсэн, тэдэнд зайлшгүй хэрэгцээт мэдлэг, чадварыг эзэмшүүлэх, амьдрах чадварт суралцахад чиглэгдсэн математикийн сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтын орчин бүрдүүлэх, багш нарын арга зүйг сайжруулах шаардлагатай байна.

ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1. Хөтөлбөрийн зорилго

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй суралцагч нь математикийн анхан шатны мэдлэг, чадвар эзэмшсэнээр математик хэл, сэтгэлгээгээ хөгжүүлж, цаашид үргэлжлүүлэн суралцахад шаардлагатай сурах арга барил эзэмшинэ.

2.2. Зорилт

- Математикийн анхан шатны мэдлэг, ойлголт эзэмших, ахуй амьдралдаа хэрэглэх
- Математик хэл, сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвараа хөгжүүлэх
- Математикт суралцах сонирхолтой болж, сурах арга барил эзэмшинэ.

ГУРАВ. АГУУЛГА

Бага боловсролын математикийн сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээ нь тоо тоолол, геометр, хэмжигдэхүүн, өгөгдөлтэй ажиллах гэсэн бүтэцтэй байна. I-V ангийн агуулгын залгамж, холбоог хүснэгтээр харуулав.